



Г НЭР БҮХИЙ 314 ҮЛ ХӨДЛӨХ ЭД Г
ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН
БАЙГУУЛЛАГАД

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2023.09.22 № ЦАТ-11/04/06

танай __-ны № __-т

Г Хуулийн хэрэгжилт хангах тухай Г

Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын салбарт оролцогчдыг анх төрийн хяналт зохицуулалтад хамруулсан 2020 оны эхний хагас жилд 103 хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ Хороонд ирүүлж, бүртгэлд хамрагдсан бол 2023 оны 09 дүгээр сарын байдлаар 312 хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхэлж, салбарын оролцогчид 3 дахин нэмэгдсэн. Тус салбарт оролцогчдын цар хүрээ нэмэгдэж, технологийн дэвшлийг ашиглан үл хөдлөх хөрөнгийн цахим зуучлал, цахим дуудлага худалдаа, үл хөдлөх хөрөнгийн түрээсийн цогц үйлчилгээг технологид суурилсан хэлбэрээр нэвтрүүлж, цаашид шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ зах зээлд нэвтэрсээр байх хандлагатай байна.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэгт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих гэж заасныг үндэслэн доорх зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, эрсдэлээс иргэд олон нийтийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдүүд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөж, шийдвэр гаргасан тохиолдолд уг үйл ажиллагааг эхлүүлэх, олон нийтэд мэдээлэхээс өмнө Хороонд шинэ бүтээгдэхүүний талаарх танилцуулгыг урьдчилан ирүүлэх;
2. Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл олгоход хянуулсан бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд шинэчилсэн бизнес төлөвлөгөөний төслийг ирүүлэх;
3. Компанийн засаглалын тогтолцоог үр дүнтэйгээр хэрэгжүүлэх нь аливаа байгууллагын урт хугацааны тогтвортой өсөлт, хөгжлийг хангахад чухал ач холбогдолтой тул Санхүүгийн зохицуулах хороо компанийн засаглалыг хэрэгжүүлэх арга зүйг шинэ түвшинд гаргах, засаглалыг сайжруулах сэдэл, хөшүүргийг бий болгож, үр өгөөжийг нь нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаж байна. Иймд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолын хавсралтаар



баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийг байгууллагын холбогдох дүрэм, журам, заавартаа тусган, үйл ажиллагаандаа дагаж мөрдөх;

4. Жендэрийн эрх тэгш байдлын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах стратеги төлөвлөгөө” (2022-2031), жендэрийн бодлого, олон улсын гэрээ, конвенцуудыг хэрэгжүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхэд салбарын хэмжээнд үйлчлүүлэгчдийн хүйс, нас, боловсрол зэргээр ангилсан өгөгдөл, статистик мэдээллийг цуглуулах ажлуудыг эхлүүлэх шаардлагатай байна. Иймд хавсралтад заасны дагуу үйлчлүүлэгчдийнхээ жендэрийн статистик мэдээллийг цуглуулах ажлыг эхлүүлж, мэдээллийг улирал тутам гаргаж хэвших, 2023 оны мэдээллийг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хорооны realestate-jender@frc.mn цахим шууданд ирүүлэх.

Цаашид Хорооноос дээрх статистик судалгааг баяжуулах, бодлого төлөвлөлт, холбогдох журмуудад тусгах, сургалтад хамруулах ажлуудыг хийхээр төлөвлөж байгаа тул Та бүхэн холбогдох саналаа Хорооны realestate-jender@frc.mn цахим шууданд ирүүлж хамтран ажиллана уу.

Жич : Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 235 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг шинэчлэн баталсан. Тус журмаар зуучлалын мэдээний загварыг сайжруулж, статистик тоо мэдээг баяжуулснаар зайны хяналт, шалгалтыг хялбаршуулсан бөгөөд санхүүгийн тайланг улирал бүр Хороонд тайлагнахаар холбогдох зохицуулалтыг тусгасан болно. Шинэчлэн баталсан журамтай дараах холбоосоор танилцана уу. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759870728851>

Хавсралт 1 хуудастай.



Үйлчлүүлэгчдийн жендэрийн статистик мэдээлэл

“.....” ХХК

№	Овог	Нэр	Хүйс	Нас	Боловсрол (дээд, бүрэн дунд гэх мэт)	Мэргэжил	Оршин суугаа газар (УБ хотод, хөдөө орон нутагт, гадаадад)	Хөдөлмөр эрхлэлт (тийм, үгүй, тэтгэвэрт)	Ажилладаг салбар (барилга, эрүүл мэнд... гэх мэт)
1									
2									
3									

